



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Засгийн газрын "Хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах тухай" 2018 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд хүмүүжлийн талаар албан хаагчдын мэдлэг туршлагыг солилцох, хүүхдүүдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, эцэг эхчүүдэд хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг ойлгуулах, нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас жил бүр тайлагнаж ажиллахыг Эцэг эхийн зөвлөлийн дарга (Д.Өлзийсайхан)-д үүрэг болгосугай.
3. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Э.Даваахатан)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай" Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500065

Газрын даргын 2023 оны 02 дугаар
сарын 09-ны өдрийн 1110 дугаар
тушаалын хавсралт



ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Байгаль орчны стандартын хэлтсийн дарга

Гишүүд:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Хотын хөгжлийн стандартын хэлтсийн
мэргэжилтэн

Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн
хэлтсийн мэргэжилтэн

Барилгын стандарт, аюулгүй байдлын
хяналтын хэлтсийн мэргэжилтэн

Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтсийн
мэргэжилтэн